

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

### МӨСТ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын код: ХОА-2021/37/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот  
2021 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh  
@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545 Цахим хаяг:  
Tsetsegsuren.A@audit.gov.mn

Гэрэл Хөхийн тэнцвэр аудит ХХК

Аудитор: Д.Хишгээ

Утас: 99964238 Цахим хаяг: Hishgee.Da@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	6
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	<b>Error! Bookmark not defined.</b>
3. Аудитын тайлан .....	7
3.1. Ерөнхий зүйл .....	7
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	8
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	8
3.4. Материаллаг байдал .....	8
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	8
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	10
3.7. Шилэн дансны мэдээлэл .....	10
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	11
3.9. Аудитын илрүүлэлт .....	11
Залруулсан алдаа .....	11
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	11
Аудитын зөвлөмж .....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	11
4. Менежментийн захидал .....	11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	12

## 1.Хараат бус аудиторын дүгнэлт

  
**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
94000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

**МӨСТ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН  
ЭРХЛЭГЧ Х.СОЁЛЭРДЭНЭ ТАНАА**

2021.01.27 № 2/04  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мөст сумын Соёлын төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**  
Мөст сумын Соёлын төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**  
Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.  
Аудитаар Мөст сумын Соёлын төвийн 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.  
Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг хариуцлага**  
Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.  
Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.СОЁЛЭРДЭНЭ

021020009

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2 720 055.00</b>	<b>8 749 994.72</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	138 539.72
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		138 535.11
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	-	4.61
3351	Байгууллагаас авах авлага		4.61
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	2 720 055.00	8 611 455.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	2 720 055.00	8 611 455.00
35410	Бичиг хэргийн материал		135 000.00
35420	Аж ахуйн материал		1 602 955.00
35440	Түлш, шатах тослох материал	2 050 000.00	6 873 500.00
35470	Бусад хангамжийн материал	670 055.00	
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1 049 719 629.26</b>	<b>1 005 458 684.02</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1 049 719 629.26	1 005 458 684.02
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1 045 050 913.26	1 000 904 147.02
39201	Барилга, байгууламж, орон сууц	1 031 111 992.70	1 031 111 992.70
39202	Хуримтлагдсан элэгдэл	31 540 542.80	62 021 252.18
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	26 103 296.50	26 103 296.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	18 935 012.67	21 495 566.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	41 980 293.00	41 980 293.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	28 211 289.47	32 316 793.00
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	12 118 900.00	12 118 900.00
39217	Ном	12 423 276.00	12 423 276.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	4 668 716.00	4 554 537.00
39301	Програм хангамж	456 716.00	456 716.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		114 179.00
39303	Бусад биет бус хөрөнгө	4 212 000.00	4 212 000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1 052 439 684.26</b>	<b>1 014 208 678.74</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1 052 439 684.26</b>	<b>1 014 208 678.74</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1 052 439 684.26	1 014 208 678.74
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	781 292 388.00	781 292 388.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	62 515 967.12	100 746 972.64
51210	Өмнөх үеийн үр дүн	129 062 512.45	130 014 313.96
51220	Тайлант үеийн үр дүн	66 546 545.33	29 267 341.32
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	333 663 263.38	333 663 263.38
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1 052 439 684.26</b>	<b>1 014 208 678.74</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>102 559 216.00</b>	<b>83 972 400.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>101 559 216.00</b>	<b>648 000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	101 559 216.00	648 000.00
	үнэ төлбөргүй хүлээн авах орлого, үндсэн хөрөнгө	99 559 216.00	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1 000 000.00</b>	<b>83 324 400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	83 324 400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		83 324 400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1 000 000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1 000 000.00	
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>109 405 070.67</b>	<b>121 251 604.01</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>109 405 070.67</b>	<b>121 251 604.01</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	109 105 070.67	117 571 600.88
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	50 531 100.00	60 427 273.00
210101	Үндсэн цалин	37 360 800.00	60 427 273.00
210104	Урамшуулал	3 000 000.00	

210105	Гэрээт ажлын хөлс	10 170 300.00	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	6 566 300.00	7 724 568.18
210201	Тэтгэврийн даатгал	4 465 100.00	5 313 397.38
210202	Тэтгэмжийн даатгал	525 300.00	602 792.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	420 200.00	482 234.16
210204	Ажилгүйдлийн даатгал	105 100.00	120 558.54
210205	Эрүүл мэндийн даатгал	1 050 600.00	1 205 585.40
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	9 252 996.00	4 157 964.46
210301	Гэрэл, цахилгаан	372 996.00	265 964.46
210302	Түлш, халаалт	8 830 000.00	3 892 000.00
210303	Цэвэр, бохир ус	50 000.00	
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1 656 000.00	610 750.00
210401	Бичиг хэрэг	60 000.00	64 000.00
210402	Тээвэр, шатахуун	1 200 000.00	501 750.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	54 000.00	
210404	Ном, хэвлэл	60 000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	282 000.00	45 000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	48 000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	48 000.00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	354 000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	100 000.00	
210604	Урсгал засвар	254 000.00	
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	47 000.00	-
210702	Дотоод албан томилолт	47 000.00	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3 630 965.00	247 000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3 493 965.00	110 000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	137 000.00	137 000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	37 018 709.67	44 404 045.24
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	110 000.00	143 100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	36 908 709.67	44 260 945.24
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	300 000.00	3 680 003.13
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	300 000.00	100 000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300 000.00	100 000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	3 580 003.13
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		3 580 003.13
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(6 845 854.67)</b>	<b>(37 279 204.01)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(6 845 854.67)</b>	<b>(37 279 204.01)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>30 000 000.0</b>	<b>83 972 400.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2 000 000.0</b>	<b>648 000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	2 000 000.0	648 000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	2 000 000.0	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2 000 000.0	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1 000 000.0</b>	<b>83 324 400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	83 324 400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		83 324 400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1 000 000.0	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1 000 000.0	
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	-	51 484 400.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/		51 484 400.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>76 392 400.0</b>	<b>83 972 400.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>76 392 400.0</b>	<b>83 972 400.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>76 092 400.0</b>	<b>80 134 496.87</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	52 531 100.0	60 107 383.49
210101	Үндсэн цалин	39 360 800.0	52 478 267.31

210102	Нэмэгдэл	3 000 000.0	7 629 116.18
210105	Гэрээт ажлын хөлс	10 170 300.0	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>6 566 300.0</b>	<b>7 854 802.92</b>
210201	Тэтгэврийн даатгал	4 465 100.0	5 757 800.00
210202	Тэтгэмжийн даатгал	525 300.0	548 275.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	420 200.0	401 523.59
210204	Ажилгүйдлийн даатгал	102 100.0	172 387.91
210205	Эрүүл мэндийн даатгал	1 050 600.0	974 815.92
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>10 743 000.0</b>	<b>10 261 460.46</b>
210301	Гэрэл, цахилгаан	372 996.0	265 964.46
210302	Түлш, халаалт	10 320 004.0	9 995 496.00
210303	Цэвэр, бохир ус	50 000.0	
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1 656 000.0</b>	<b>582 750.00</b>
210401	Бичиг хэрэг	60 000.0	60 000.00
210402	Тээвэр, шатахуун	1 200 000.0	191 750.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	54 000.0	49 000.00
210404	Ном, хэвлэл	60 000.0	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	282 000.0	282 000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>48 000.0</b>	<b>-</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	48 000.0	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>354 000.0</b>	<b>86 000.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	100 000.0	86 000.00
210604	Урсгал засвар	254 000.0	
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>47 000.0</b>	<b>-</b>
210702	Дотоод албан томилолт	47 000.0	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4 037 000.0</b>	<b>1 187 100.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3 900 000.0	1 050 100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	137 000.0	137 000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>110 000.0</b>	<b>55 000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	110 000.0	55 000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>300 000.0</b>	<b>3 837 903.13</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>300 000.0</b>	<b>257 900.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300 000.0	257 900.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>-</b>	<b>3 580 003.13</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		3 580 003.13
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>73 392 400.0</b>	<b>-</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>73 392 400.0</b>	<b>-</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
				Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2020оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	781 292 388.00	333 663 263.38	62 515 967.12	1 052 439 684.26
Тайлант үеийн үр дүн			38 231 005.00	38 231 005.00
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	781 292 388.00	333 663 263.38	100 746 972.64	1 215 702 624.02

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	85 324 500.00	80 392 396.90
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	85 024 500.00	80 392 396.90
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	85 024 500.00	80 134 496.90
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	60 608 800.00	60 107 383.50
210101	Үндсэн цалин	52 892 200.00	52 478 267.31
210102	Нэмэгдэл	7 716 600.00	7 629 116.18
210105	Гэрээт ажлын хөлс		
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	8 182 200.00	7 854 802.92
210201	Тэтгэврийн даатгал	5 757 800.00	5 757 800.00

210202	Тэтгэмжийн даатгал	606 100.00	548 275.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	484 900.00	401 523.59
210204	Ажилгүйдлийн даатгал	121 200.00	172 387.91
210205	Эрүүл мэндийн даатгал	1 212 200.00	974 815.92
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>10 881 600.00</b>	<b>10 261 460.46</b>
210301	Гэрэл, цахилгаан	831 600.00	265 964.46
210302	Түлш, халаалт	10 000 000.00	9 995 496.00
210303	Цэвэр, бохир ус	50 000.00	
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>656 000.00</b>	<b>582 750.00</b>
210401	Бичиг хэрэг	60 000.00	60 000.00
210402	Тээвэр, шатахуун	200 000.00	191 750.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	54 000.00	
210404	Ном, хэвлэл	60 000.00	49 000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	282 000.00	282 000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>48 000.00</b>	<b>-</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	48 000.00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>354 000.00</b>	<b>86 000.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	100 000.00	86 000.00
210604	Урсгал засвар	254 000.00	
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	<b>147 000.00</b>	<b>-</b>
210702	Дотоод албан томиллолт	147 000.00	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5 087 000.00</b>	<b>1 187 100.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4 036 900.00	1 050 100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	137 000.00	137 000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>110 000.00</b>	<b>55 000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	110 000.00	55 000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>300 000.00</b>	<b>257 900.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>300 000.00</b>	<b>257 900.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300 000.00	257 900.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>85 324 500.00</b>	<b>80 392 396.90</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>83 324 400.00</b>	<b>79 744 396.90</b>
132001	Орон нутгийн төсвөөс	83 324 400.00	79 744 396.90
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>2 000 000.00</b>	<b>648 000.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2 000 000.00	648 000.00
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>7.00</b>	<b>7.00</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	3.00	3.00
620003	Үйлчлэх ажилтан	1.00	1.00
620004	Гэрээт ажилтан	2.00	2.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Мөст сумын Соёлын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төсвийн шууд захирагч Хархүү овогтой Болд-Эрдэнэ танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгийг зөв ангилал нягтлан бодох бүртгэлд тусгах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 19 -наас 2021 оны 01 дүгээр сарын 21-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагатай гэрээ байгуулж

Гэрэлт Хөхийн тэнцвэр аудит ХХК-ны Ховд аймаг дахь салбарын захирал аудитор Д.Хишгээ хариуцаж хэрэгжүүлэв.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Үндэсний өв соёлоо эрхэмлэн хадгалж, түгээн дэлгэрүүлж, соёлын үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэнэ. Үүнд:

- соёлын үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд мэргэжлийн ур чадвар, үйлчилгээний өндөр түвшинд явуулах
- төсөв, төслийн болон хандивын хөрөнгийг зориулалтаар нь үр ашигтай зарцуулах
- соёлын ажилтны мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, нийгмийн баталгааг нь хангах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай”

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Тус байгууллага нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлого сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн тайлангийн нийт орлого 175951.6 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 1759.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

Гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар 2425,0 мянган төгрөгөөр тооцлоо.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Мөст сумын Соёлын төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 38230,9 мянган төгрөгөөр буюу 3.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

## Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага		138.5	
Урьдчилгаа			
Бараа материал	2 720.0	8 611.5	- 5 891.50
Үндсэн хөрөнгө	1 049 719.6	1 005 458.7	44 260.90
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1052439.6</b>	<b>1014208.7</b>	<b>38 230.90</b>
Өр төлбөр			-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1052439.6	1014208.7	38 230.90
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1052439.6</b>	<b>1014208.7</b>	<b>38 230.90</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 8611.5 мянган төгрөг болж 5891.4 мянган төгрөгөөр өссөн нь түлш худалдан авч нөөцөлснөөс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэлд 2020 онд бичиг хэрэг 199.0, аж ахуйн материал 1088.4, түлш шатахуун 7398.5 нөөцийн бараа 518.9 бүгд 9204.8 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч бичиг хэрэгт 64.0, аж ахуйн материалд 155.5, түлш шатах тослох материал 2575.0, нөөцийн бараа 518.9 бүгд 3313.4 мянган төгрөгийн бараа материал зарцуулж 2020 онд бичиг хэрэг 135.0, аж ахуйн материал 1602.9, түлш шатах тослох материал 6873.5 бүгд 8611.5 мянган төгрөгийн бараа материал байна.

Оны эцэст 7398.5 мянган төгрөгийн түлш шатах тослох материал худалдан авалт хийж түлшний 6873.5 мянган төгрөгийн бараа материалын нөөц үүсгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1128406.4 мянган төгрөг болж өмнөх оноос ямар нэгэн өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 781292,4 мянган төгрөг болж өмнөх оноос өөрчлөгдөөгүй байна.

Тус байгууллагын 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 92979.2 мянган төгрөгөөр буюу 52 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь Мөст сумын Соёлын төвийн барилгад улсын төсвийн хөрөнгөөр их засвар хийж хандив тусламжийн орлогоор бүртгэсэнтэй холбоотой байна.

Тайлант жилд орон нутгийн санхүүгийн дэмжлэгээр 83324.5 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг авахаас, гүйцэтгэлээр 80392.4 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч 3580.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг буцаан төвлөрүүлсэн байна.

Өөрийн орлогын 2000.0 сая төгрөгийн орлого бүрдүүлэх төлөвлөгөөтэйгөөс, гүйцэтгэлээр 648.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж батлагдсан төлөвлөгөөг 1352.0 мянган төгрөгөөр тасалсан нь Ковид-19 цар тахлын цаг үеийн нөлөөлөлөөс шалтгаалсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны Мон Эн Ко компанид өгөх нүүрсний үнэ 1279.9, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 328.9 мянган төгрөг төгрөгийг тайлан балансанд тусгаагүйг өмнөх оны үр дүн дансанд 951.8 мянган төгрөгөөр нягтлан бодох бүртгэлийн залруулга нь хийгдсэн болно.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй. Тайлант жилд нэмэлт дансаар ямар нэгэн гүйлгээ хийгдээгүй байна.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 86374.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 86374.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1050.1 мянган төгрөгөөр бууруулж 85324.5 мянган төгрөгөөр баталсан байна.

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 10 хөтөлбөрийн 44 арга хэмжээг санхүүжүүлэхээр 85324.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 83324.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс 2000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 79744.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 648.0 мянган төгрөг, нийт 80392.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 80392.4 мянган төгрөгийг зарцуулж 3580.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 80392.4 мянган төгрөг буюу 95 хувьтай байгаа нь бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлыг 2849.8 мянган төгрөгөөр, цалин хөлс НДШ-ийн зардлыг 828.8 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 620.1, эд хогшил худалдан авах зардлыг 268.0 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 147.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт 5 хөтөлбөрийн 35 арга хэмжээ хэрэгжүүлэхэд 85324.5 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг зарцуулахаас 8 зардлын хэмнэлтээс 3580.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг буцаан төвлөрүүлсэн.

#### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд ямар нэгэн нэмэлт санхүүжилт аваагүй байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 107 мэдээллээс хугацаандаа оруулсан 99 мэдээлэл, хугацаа хоцроож 8 мэдээлсэн байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 318,0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн актыг биелүүлсэн байна. Аудитаар тус байгууллагад нярвын тайланг цаг тухай бүр гаргаж хэвшүүлэх зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/ мян төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	318,0	1	318,0			
Албан шаардлага							
Зөвлөмж	1		1				
Нийт дүн	2	318,0	2	318,0			

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2012,6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1746,6 мянган төгрөгийн алдааг залруулж, 118,0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 148,0 мянган төгрөгний зөрчилд зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Мөст сумын Соёлын төвийн ажилчдын цалин хөлснөөс ХХОАТ дутуу суутгасан 118,0 мянган төгрөгний зөрчилд төлбөрийн акт бичлээ. Энэ нь 14.1.Энэ хуулийн 7.1-д заасан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасна гэсэн хуулийн заалттай нийцэхгүй байна.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## 4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### Зардлын данстай холбоотой асуудал

- 1.1. **Илрүүлэлт:** 2013-2014 оны хувь хүнтэй холбоотой санхүүгийн хяналт шалгалтын актыг байгууллагын цалингийн зардлааас шилжүүлсэн
- 1.2. **Эрсдэл:** хөрөнгийн өгөөж буурна.
- 1.3. **Өгсөн зөвлөмж:** төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

